

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

ШУТИС-ийн МХТС-ийн захирал... /Н.Чулуунбанди/

**ШУТИС-ийн нэрэмжит  
“ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ”-ийн  
УЛСЫН НЭЭЛТТЭЙ IV олимпиадын удирдамж**

**НЭГ. Үндэслэл.**

Мэдлэгт сууринсан эдийн засаг, алсын хараа 2050 шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, төр-шинжлэх ухаан-бизнесийн ажиллагааг төгөлдөржүүлэхэд асуудал судлаачдын анхааралд байгаа билээ. Улс орны аль ч салбарт эдийн засаг менежмент, инженерчлэлийн ур чадвартай боловсон хүчнийг бэлтгэх нь боловсролын байгууллагын гол зорилт болж байна, үүнд манай улсын их дээд сургуулиудын эрдэмтэн багш, оюутан судлаачдын хамтын ажиллагаа ихээхэн хувь нэмэр оруулах болно.

**ХОЁР. Зорилго.**

Инженерийн чиглэлээр суралцагч оюутан нь инженерчлэлийн эдийн засгийн мэдлэгтэйгээр сайн инженер, сайн мэргэжилтэн болох тул тэдний идэвх сонирхлыг сайжруулах, хичээлээр авсан мэдлэгийг өргөтгөх, бататгах, сэтгэн бodoх чадварыг хөгжүүлэхэд олимпиадын зорилго оршино.

Суралцагч оюутанд инженер техникийн шаардлагатай асуудлыг эдийн засгийн хувьд хэмнэлттэйгээр бүтээх арга замыг эрэлхийлэх, инженерчлэлийн эдийн засгийн хувилбарууд, оновчтой шийдэл гаргах, төсөл дээр ажиллах ур чадвар, дадал олгоход тус олимпиадын зорилго чиглэгдэнэ.

**ГУРАВ. Олимпиадын зохион байгуулалт.**

- 3.1. Инженерчлэлийн эдийн засгийн улсын IV олимпиадыг их дээд сургуулиудын оюутнуудын дунд нээлттэй зохион байгуулна.
- 3.2. Олимпиадад их дээд сургуульд инженерчлэлийн эдийн засаг, эдийн засгийн онол, макро микро эдийн засгийн онол, санхүүгийн болон төслийн менежмент зэрэг хичээлийг судалсан болон судалж буй оюутнууд удирдагч багшийн удирдлагаар (хамт) хувийн болон багийн зохион байгуулалттайгаар оролцоно. Нэг баг 3-5 оюутантай байна.
- 3.3. Олимпиадыг хоёр үе шаттай зохион байгуулна.
  - 3.3.1. Олимпиадад оролцох сургууль, удирдагч багш нар I шатны сонгон шалгаруулалтыг тухайн оролцогч сургууль, тэнхим, салбар хөтөлбөрийн оюутнуудын дунд удирдан зохион байгуулна. II шатанд оролцох оюутан өөрийн мэдээллийг <https://docs.google.com/forms-d> бүртгүүлнэ, удирдагч багш хянана.
  - 3.3.2. II шатанд шалгарсан оюутнууд 2023 оны 11 сарын 20-ний дотор удирдагч багшаар дамжуулж Мандатыг урьдчилан авна. Техникийн комисс google forms-ын мэдээллийн дагуу үнэмлэхийн хуулбар (иргэний эсвэл оюутны), цээж зурагт баталгаажуулалт хийж, мандатыг олгоно.
  - 3.3.3. II үе шат 2023 оны 11 дугаар сарын 25-ны өдөр (бямба гаригт) ШУТИС-ийн хичээлийн 6-р байр буюу Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль дээр танхимаар зохион байгуулна.

**ДӨРӨВ. Зохион байгуулах комисс.**

Олимпиадыг оролцогч сургуулийн төлөөлөл, багш нарын бүрэлдхүүнтэй дараах комисс 2 зохион байгуулна.

- 4.1. Ерөнхий комисст сургууль бүрээс 1 хүртэлх багш ажилтан орж, олимпиадын зохион байгуулалт, хамтын ажиллагааг хангана.
- 4.2. Шалгалтын комисст сургууль бүрээс заавал 1 багш ажилтан орж, шалгалтын материал боловсруулах, засах, дүн гаргах ажиллагааг гүйцэтгэнэ.
- 4.3. Комиссуудын нэгдсэн анхны зөвлөгөөн 2023 оны 10 сарын 30-ны 14 цагаас цахимаар болох ба үүгээр шалгалтын агуулга, дүгнэх аргачлалыг шийднэ.
- 4.4. Олимпиадын талаар мэдээлэл авах, урьдчилсан санал, шийдлийн талаар комиссын гишүүн Ч.Оюу, Ц.Балжинням (имэйл [tsbaljinnyam@must.edu.mn](mailto:tsbaljinnyam@must.edu.mn), утас 80084583, 88138897) нартай холбогдон өгч болно.

**ТАВ. Шалгаруулалт, шагнал урамшуулал.**

- 5.1. II шатанд хувийн дүнгээр нэгдүгээр байр 1, хоёрдугаар байр 1, гуравдугаар байр 1, тусгай байранд 1 оюутан шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

I байр	Нэг	Тус бүр 200 000 ₮, өргөмжлөл
II байр	Нэг	Тус бүр 150 000 ₮, өргөмжлөл
III байр	Нэг	Тус бүр 100 000 ₮, өргөмжлөл
Тусгай байр	Хоёр	Тус бүр 80 000 ₮, өргөмжлөл

- 5.2. II шатанд багийн дүнгээр нэгдүгээр байр 1, хоёрдугаар байр 1, гуравдугаар байр 1, тусгай байранд 1 оюутан шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

I байр	Нэг	Тус бүр 300 000 ₮, өргөмжлөл
II байр	Нэг	Тус бүр 200 000 ₮, өргөмжлөл
III байр	Нэг	Тус бүр 100 000 ₮, өргөмжлөл
Тусгай байр	Хоёр	Тус бүр 80 000 ₮, өргөмжлөл

- 5.3. Мөн олимпиадын II шатанд оролцож, авбал зохих нийт онооны 70 –аас дээш хувийг авсан оюутнуудад батламж олгоно. Олимпиадад оролцсон оюутнуудад удирдагч багш явцын шалгалтын болон улирлын шалгалтын оноог шууд тооцож болно.

**Олимпиадын ерөнхий зохион байгуулагч:**

**ШУТИС-ийн Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль**

2023.10.25